



БАЯНХОНГОР АЙМАГ
ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 04 өдөр

Дугаар А/03

Эмзэлтолгой

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өлзийт-Өндөр 2 дугаар багийн Хөх нуурт нутаглаж буй малчин Ж.Гантулгын хотонд галзуу Чоно орж мал барьсан тул галзуу чонын сэг зэмийг устгах, хүн, малд галзуугийн вакцин хийх, ариутгал халдваргүйжүүлэлт зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Д.Ганзориг	(Засаг даргын орлогч)
Гишүүд:	Ж.Должинсүрэн	(Өлзийт-Өндөр 2 дугаар багийн Засаг дарга)
	Б.Алтангадас	(Сум дундын цагдаагийн тасгийн дарга, ахмад)
	Г.Алтантуяа	(Эрүүл мэндийн төвийн дарга)
	С.Нанжид	(Малын эмч)
	Д.Баасанжаргал	(Эрэн хайх, аврах салбарын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Нарийн бичгийн дарга:	Ж.Сүхбаатар	(Байгаль орчны хяналтын Улсын байцаагч)

2. Галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх, сэг зэмийг устгах, ариутгал, вакцинжуулалтын ажлыг чанартай хийж гүйцэтгэн ажлын үр дүнг тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Ганзориг)-д үүрэг болгосугай

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (Б..Өнөрбаяр)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХЖАРГАЛ

